



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/22/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2022 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273204 Цахим хаяг: maitsetsegt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
3.4.1 Мөнгөн хөрөнгө	11
3.5.2 Авлага	11
3.5.4 Бараа материал	12
3.5.6 Үндсэн хөрөнгө	12
3.5.7 Өр төлбөр	13
3.5.10 Засгийн газрын хувь оролцоо.....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.2 Зөвлөмж.....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.03.24 № 01/236
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН БАЯН СУМЫН ЗАСАГ
ДАРГА М.МӨНХ-ЭРДЭНЭ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Баян сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баян сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төв аймгийн Баян сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын батлагдсан төлөвлөгөө 1,613,714.1 мянган төгрөг, гүйцэтгэлээр 1,155,459.6 мянган төгрөг төвлөрч, батлагдсан төлөвлөгөө 71,6 хувиар биелж 458,254.5 мянган төгрөгөөр тасарсан, нэр төрлөөр авч үзэхэд 6 нэр төрлийн орлого 20,9-98,5 хувиар тасарч төлөвлөлтийн үе шатанд тооцсон материаллаг байдлын түвшин 33,187.3 мянган төгрөгөөс хэтэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заалт болон санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 30-ны А/45 дугаар захирамжаар сумдын 2022 оны үйл ажиллагааны үр дүнг дүгнэж баталгаажуулсан тайлангаар Баян сум нь сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 77,6 хувь, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт 88,0 хувьтай, ерөнхий үнэлгээгээр 82,5 хувьтай буюу В үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Сангийн яамны 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10/84 дугаартай албан бичгээр ирүүлсэн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах чиглэлийн дагуу гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн байгууллагуудын 2,719,446.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 138,190.5 мянган төгрөгийн бараа материал, 52,431.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг шилжүүлэн тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		2,153,665.3	1,521,976.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	1,717,313.6	1,163,450.1
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	221,089.4	256,592.0
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	215,262.3	101,934.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		4,871,006.6	2,553,345.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	4,871,006.6	2,553,345.2
39200	Биет хөрөнгө		4,088,141.6	1,851,032.7
39300	Биет бус хөрөнгө	13	782,865.0	702,312.5
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		7,024,671.9	4,075,321.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		25,738.6	12,190.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	25,738.6	12,190.0
41300	Өглөг	17а, 17б	25,738.6	12,190.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		6,998,933.3	4,063,131.3
51	Засгийн газрын хувь оролцоо		6,998,933.3	4,063,131.3
51100	Засгийн газрын оруулсан капитал		2,332,329.3	1,268,467.9
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		2,332,329.3	1,268,467.9
51200	Хуримтлагдсан үр дүн		2,746,982.7	1,833,071.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,919,621.3	961,591.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		7,024,671.9	4,075,321.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		4,812,414.8	1,920,609.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО		245,937.5	1,124,992.1
110	Орлогын албан татвар		45,112.4	283,890.7
1100	Хувь хүний орлогын албан татвар		45,112.4	299,782.5
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		0.0	-15,891.8
113	Хөрөнгийн албан татвар		690.0	33,525.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж		200,135.1	807,576.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	1,554,646.5	208,070.6
120	Нийтлэг татварын бус орлого		1,554,646.5	208,070.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		3,011,830.8	587,546.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	3,492,217.9	1,951,868.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,492,217.9	1,132,343.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,434,328.6	889,579.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,131,468.8	266,781.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		148,168.4	32,675.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		286,968.6	291,306.5
2104	Хангамж, бараа материалын зардал		71,270.3	30,413.4
2105	Нормативт зардал		313,972.6	25,364.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		41,604.8	4,638.2
2107	Томилолт, зочны зардал		1,186.0	2,452.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,		6,275.8	33,712.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		433,413.2	202,234.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,057,889.3	242,764.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0.0	819,524.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		1,320,196.9	-31,259.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		131,023.2	2,858,856.8
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		1,189,173.7	-2,890,116.0

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,439,343.3	1,836,442.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	245,937.5	1,126,655.2
110	Орлогын албан татвар	45,112.4	285,553.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	45,112.4	301,445.7
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-15,891.8
113	Хөрөнгийн албан татвар	690.0	33,525.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж	200,135.1	807,576.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	32,292.4	14,958.6
1181	Газрын төлбөр	157,108.8	569,094.6
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	10,733.9	223,522.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,234,006.0	122,241.3
120	Нийтлэг татварын бус орлого	1,234,006.0	122,241.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,959,399.8	587,546.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,986,708.5	1,008,686.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,986,708.5	1,008,686.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,927,264.2	727,923.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,131,294.2	239,443.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	148,168.4	32,675.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	286,965.2	291,306.5
2104	Хангамж, бараа материалын зардал	47,146.5	27,235.5
2105	Нормативт зардал	92,964.9	33,404.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,609.8	5,129.8
2107	Томилолт, зочны зардал	1,186.0	2,452.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	2,952.1	33,152.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	206,977.0	63,123.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,059,444.2	280,762.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,452,634.8	827,756.9
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	133,685.5	1,325,648.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	133,685.5	1,325,648.1
2200	Дотоод эх үүсвэрээр	133,685.5	1,325,648.1
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-133,685.5	-1,325,648.1
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН	-1,101.4	-55,972.4
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,101.4	55,972.4
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,317,847.9	-553,863.5
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	399,465.7	1,717,313.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,717,313.6	1,163,450.1

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,809,759.5	5,809,759.5
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	81.9	81.9
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,809,841.4	5,809,841.4
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-81.9	-81.9
9	Тайлант үеийн үр дүн	1,189,173.7	1,189,173.7
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,998,933.3	6,998,933.3
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,998,933.3	6,998,933.3
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-63,211.8	-63,211.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,935,721.5	6,935,721.5
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-1,031.7	-1,031.7
19	Тайлант үеийн үр дүн	-2,890,116.0	-2,890,116.0
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,063,131.3	4,063,131.3

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,201,564,600.00	2,079,503,310.90	1,122,061,289.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	760,051,100.00	697,882,837.90	62,168,262.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	747,304,300.00	685,141,051.90	62,163,248.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	308,945,500.00	266,956,038.07	41,989,461.93
210101	Үндсэн цалин	234,977,700.00	204,482,658.08	30,495,041.92
210102	Нэмэгдэл	59,516,400.00	41,551,488.12	17,964,911.88
210104	Урамшуулал	14,451,400.00	17,596,231.87	-3,144,831.87
210105	Гэрээт ажлын хөлс	0	3,325,660.00	-3,325,660.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,047,900.00	32,675,525.82	8,372,374.18
210201	Тэтгэврийн даатгал	28,690,400.00	22,798,171.39	5,892,228.61
210202	Тэтгэмжийн даатгал	3,089,700.00	2,670,628.42	419,071.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,471,400.00	2,136,402.92	334,997.08
210204	Ажилгүйдлийн даатгал	617,700.00	458,243.99	159,456.01
210205	Эрүүл мэндийн даатгал	6,178,700.00	4,612,079.10	1,566,620.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	297,432,900.00	291,306,516.57	6,126,383.43
210301	Гэрэл, цахилгаан	26,681,800.00	20,483,949.19	6,197,850.81
210302	Түлш, халаалт	269,640,100.00	269,633,067.38	7,032.62
210303	Цэвэр, бохир ус	1,111,000.00	1,189,500.00	-78,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,232,800.00	26,179,800.00	53,000.00
210401	Бичиг хэрэг	1,497,900.00	2,436,700.00	-938,800.00
210402	Тээвэр, шатахуун	10,486,400.00	10,615,550.00	-129,150.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,748,500.00	636,000.00	1,112,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,500,000.00	12,491,550.00	8,450.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,150,000.00	5,129,760.00	20,240.00
210604	Урсгал засвар	5,150,000.00	5,129,760.00	20,240.00
2107	Томилолт, зочны зардал	2,514,900.00	2,452,000.00	62,900.00
210702	Дотоод албан томилолт	2,514,900.00	2,452,000.00	62,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	36,987,300.00	32,726,389.44	4,260,910.56
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	32,997,500.00	28,986,931.44	4,010,568.56
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	712,800.00	712,800.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	0	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	486,800.00	486,800.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	240,000.00	239,658.00	342.00
210807	Газрын төлбөр	2,300,200.00	2,300,200.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,993,000.00	27,715,022.00	1,277,978.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,993,000.00	24,847,222.00	1,145,778.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.00	2,867,800.00	132,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,746,800.00	12,741,786.00	5,014.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,746,800.00	12,741,786.00	5,014.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	10,746,800.00	10,746,786.00	14.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	1,995,000.00	5,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,201,738,100.00	1,325,648,073.00	876,090,027.00
220001	Барилга байгууламж	607,914,900.00	327,539,348.00	280,375,552.00
221001	Их засвар	918,462,100.00	911,152,365.00	7,309,735.00
222001	Тоног төхөөрөмж	28,068,300.00	67,141,422.00	-39,073,122.00
223001	Бусад хөрөнгө	647,292,800.00	19,814,938.00	627,477,862.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	239,775,400.00	55,972,400.00	183,803,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	239,775,400.00	55,972,400.00	183,803,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,201,564,600.00	1,904,757,980.49	1,296,806,619.51
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	526,376,100.00	526,376,100.00	0.00
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	526,376,100.00	526,376,100.00	0.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,286,397,100.00	1,339,122,784.13	-52,725,684.13
320001	Орон нутгийн төсвөөс	1,286,397,100.00	1,339,122,784.13	-52,725,684.13
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,388,791,400.00	39,259,096.36	1,349,532,303.64
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	239,775,400.00	39,259,096.36	200,516,303.64
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,149,016,000.00	0	1,149,016,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	0	764,218,064.19	-764,218,064.19
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	0	580,764,808.55	-580,764,808.55

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	219,868,577.19	60,870,311.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	219,868,577.19	60,870,311.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	161,878,829.50	33,843,299.98
2104	Хангамж, бараа материалын зардал	145,727.00	1,055,700.00
210401	Бичиг хэрэг	145,727.00	0
210402	Тээвэр, шатахуун	0	1,055,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	990,304.50	0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	990,304.50	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	160,742,798.00	32,787,599.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	156,338,798.00	32,787,599.98
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,404,000.00	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,989,747.69	27,027,011.17
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,258,000.00	0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	27,399,400.00	0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,850,600.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,008,000.00	0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,731,747.69	27,027,011.17
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	24,731,747.69	27,027,011.17
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	219,868,577.19	60,870,311.15
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	219,868,577.19	60,870,311.15
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	70,959,257.90	5,693,837.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	44,761,619.29	55,176,474.15
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	104,147,700.00	0
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0	0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баян сумын Засаг дарга нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн” гэж заасан ба мөн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д “Сумын Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 59.1.1-59.1.23-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 14.2.1-14.2.12-т заасан бүрэн эрхийг, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлэн, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаа аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид нэгтгэн тайлагнадаг байна.

Нийгмийн хариуцлагын гэрээний дагуу Сэтгэлийн үүр ХХК 772.7 мянган төгрөг, Тэвхэн ХХК 10,058.0 мянган төгрөг, Улз групп ХХК 6,300.0 мянган төгрөг, Ти жи Вай ХХК 7,820.0 мянган төгрөг, Ди Ар Си ХХК 2,970.0 мянган төгрөг, Оргил цэнэг ХХК 15,500.0 мянган төгрөг, Монкоул петро майнинг ХХК 3,200.0 мянган төгрөг, Петрокоул ХХК 3,000.0 мянган төгрөг, Цэцэнс майнинг энд энержи ХХК 24,950.0 мянган төгрөг, нийт 74,570.7 мянган төгрөгийн засвар үйлчилгээ, оюутны төлбөр, ахмадад настанд дэмжлэг, баяр наадам, тоног төхөөрөмж авах зэрэгт зарцуулсан байна.

Төв аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 30-ны А/45 дугаар захирамжаар сумдын 2022 оны үйл ажиллагааны үр дүнг дүгнэж баталгаажуулсан тайлангаар Баян сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 77,6 хувь, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт 88 хувьтай, ерөнхий үнэлгээгээр 82,5 хувьтай буюу В үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор сумын Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг 43 зорилт 147 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр, Сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор 2022 оны хөгжлийн төлөвлөгөөг 39 зорилт 145 хэрэгжүүлэх арга хэмжээтэй батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 2022 оны байдлаар бүрэн биелсэн 43, тодорхой үр дүнд хүрсэн 75, эрчимжүүлэх шаардлагатай 18, үр дүнгүй буюу хугацаа болоогүй 9, нийт 79,6%-тай, 2022 оны хөгжлийн төлөвлөгөө бүрэн биелсэн 63 тодорхой үр дүнд хүрсэн 67, эрчимжүүлэх шаардлагатай 11, үр дүнгүй буюу хугацаа болоогүй 5, үнэлэх боломжгүй 1 нийт 82,6 % -тай хэрэгжиж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Баян сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамрагдаагүй, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Баян сумын Засаг дарга нь дотоод хяналт, шалгалт хийгдсэн тайлан мэдээлэл ирүүлээгүй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баян сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Баян сумын Засаг даргын нэгтгэсэн тайланд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баян сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 4,075,321.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,949,350.5 мянган төгрөгөөр буюу 58,0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,717,313.6	1,163,450.1	-553,863.5
Авлага	221,089.3	256,592.0	35,502.7
Бараа материал	215,262.3	101,934.0	-113,328.3
Үндсэн хөрөнгө	4,871,006.6	2,553,345.2	-2,317,661.3
Нийт хөрөнгө	7,024,671.8	4,075,321.3	-2,949,350.5
Өр төлбөр	25,738.6	12,190.0	-13,548.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	6,998,933.2	4,063,131.3	-2,935,801.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	7,024,671.8	4,075,321.3	-2,949,350.5

Дээрх хүснэгтээс мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 1,163,450.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 553,863.5 мянган төгрөгөөр буурсан нь орон нутгийн шилжих үлдэгдлээс хөрөнгийн зардалд зарцуулснаар өмнөх оноос орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл 383,453.6 мянган төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн сангийн үлдэгдэл 164,088.0 мянган төгрөгөөр тус тус буурч, Эрүүл мэндийн төвийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 10,803.9 мянган төгрөгийг улсын төсвийн байгууллагад шилжсэнтэй холбоотой байна.

Авлагын дансны эцсийн үлдэгдэл 35,502.5 мянган төгрөгөөр өссөн нь ЗДТГ тайлант онд хийгдэж дуусаагүй 75,995.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг болон Төв аймгаас хуваарилсан 2,640.0 мянган төгрөгийн өвсийг татаж авч амжаагүйгээс авлага

шинээр үүсгэн бүртгэсэн нь нөлөөлсөн байна.

Бараа материалын оны эхний үлдэгдэл 113,328.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд 104,714.2 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС-ийн 42,511.9 мянган төгрөг, цэцэрлэгийн 31,666.4 мянган төгрөг, Эрүүл мэндийн төвийн 45,454.6 мянган төгрөг, Соёлын төвийн 18,557.5 мянган төгрөг, нийт 138,190.5 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг улсын төсвийн байгууллагад шилжүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 3,416,123.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 697,887.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн байгууллагууд ЕБС-ийн 1,604,696.1 мянган төгрөгийн, цэцэрлэгийн 397,316.3 мянган төгрөгийн, эрүүл мэндийн төвийн 453,059.6 мянган төгрөгийн, соёлын төвийн 264,374.8 мянган төгрөгийн, нийт 2,719,446.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ нь 4,063,131.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,935,801.9 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн, Соёлын төвийн байгууллагуудын авлага, засгийн газрын сан, дахин үнэлгээний нэмэгдлийг өмнөх үеийн үр дүн дансанд хааж, тайлант оны үр дүн буурснаас шалтгаалсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 1,163,450.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 553,863.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	1,717,313.6	1,163,450.1	-553,863.5
Төгрөг	1,717,313.6	1,163,450.1	-553,863.5
Төрийн сангийн харилцах	1,716,197.9	1,153,466.0	-562,731.9
Арилжааны банк дахь харилцах	1,115.7	9,984.1	8,868.4
Дүн	1,717,313.6	1,163,450.1	-553,863.5

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн Төрийн сангийн харилцах дансны эцсийн үлдэгдэл 1,153,466.0 мянган төгрөгийн 44,9 хувь буюу 518,206.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн ерөнхий орлогын, 37,2 хувь буюу 428,722.7 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн, 13,2 хувь буюу 152,042.1 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн, 4,7 хувь буюу 54,495.1 мянган төгрөгийг байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангийн харилцах дансны үлдэгдэл эзэлж байна.

Э тайланд байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа санг мал хамгаалах сан гэсэн нэрээр тайлагнасан байна. Эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл арилжааны банканд байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 256,591.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 35,502.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	22,728.3	8,715.9	-14,012.4
Байгууллагаас авах авлага	66,894.1	149,225.5	82,331.4
Хувь хүмүүсээс авах авлага	131,467.0	98,650.5	-32,816.5
Дүн	221,089.4	256,591.9	35,502.5

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны эцсийн үлдэгдэл 256,591.9 мянган төгрөгийн 64,7 хувь буюу 166,122.3 мянган төгрөгийг хоршоо, хөгжүүлэх сангийн, 30,6 хувь буюу 78,635.0 мянган төгрөгийг ЗДТГ-ын, 3,4 хувь буюу 8,716.0 мянган төгрөгийг эмийн эргэлтийн сангийн, 1,2 хувь буюу 3,118.7 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн авлага байна.

Аудитын илрүүлэлт

Нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайланд Орон нутгийн хөгжлийн санд 1,118.7 мянган төгрөгийн авлагыг бүртгэхдээ бусад орлогоор буруу тайлагнасан алдааг залруулсан.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 101,934.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 113,328.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	50,690.5	19,297.1	-31,393.4
Тусгай зориулалттай материал	22,212.2	2,051.5	-20,160.7
Эм боох материал	28,478.3	17,245.6	-11,232.7
Хангамжийн материал	157,581.8	71,567.0	-86,014.8
Бичиг хэргийн материал	6,448.5	2,459.6	-3,988.9
Аж ахуйн материал	79,105.3	52,331.4	-26,773.9
Сэлбэг хэрэгсэл	1,376.3	970.0	-406.3
Барилгын засварын материал	2,522.5	0.0	-2,522.5
Хүнсний материал	4,409.5	0.0	-4,409.5
Бусад хангамжийн материал	63,719.7	15,806.0	-47,913.7
Мал амьтад	6,990.0	11,070.0	4,080.0
Дүн	215,262.3	101,934.1	-113,328.2

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын эцсийн үлдэгдэл 101,934.1 мянган төгрөгийн 81,2 хувийг ЗДТГ, 15,2 хувийг эмийн эргэлтийн сан, 3,6 хувийг ИТХ-ын бараа материал эзэлж байна.

Аудитын илрүүлэлт

ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар:

- Сумын төв доторх 2 км замын зураг төсвийн үнэ 40,000.0 мянган төгрөгийг аж ахуйн материал дансанд орлогоор тайлагнасныг авлагаар бүртгэж залруулсан.
- Бичиг хэргийн материал дансанд 360.0 мянган төгрөгийн 20 боодол бичгийн цаас, 566.0 мянган төгрөгийн 17ш принтерийн хорны, бусад хангамжийн материал дансанд 1,880.0 мянган төгрөгийн үнэтэй 47ш улиас, 5,000.0 мянган төгрөгийн үнэтэй 1000ш шар хуайс, үлдэгдэлтэй зөрчилд албан шаардлага бичигдсэн

Засаг даргын нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайланд улсын төсвийн байгууллагууд харьяа дээд байгууллагадаа нэгтгэгдэхтэй холбоотойгоор 138,190.4 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлж, үнэ төлбөргүй гарсан зардалд тайлагнаагүй байсныг залруулан тайлагнасан.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 2,553,345.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,317,661.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	7,256,894.6	3,920,830.0	-3,336,064.6
Барилга, байгууламж, орон сууц	5,647,517.7	2,793,742.8	-2,853,774.9
Авто-тээврийн хэрэгсэл	307,406.0	230,076.0	-77,330.0
Машин тоног төхөөрөмж(компьютер)	432,763.6	119,833.7	-312,929.9
Тавилга, аж ахуйн эд хогшил	185,160.9	44,779.7	-140,381.2
Бусад үндсэн хөрөнгө	676,588.9	434,858.5	-241,730.4
Дуусаагүй барилга, байгууламж	7,417.5	297,539.3	290,121.8
Ном	40.0	0.0	-40.0
Биет бус хөрөнгө	787,609.5	707,550.5	-80,059.0
Программ хангамж	9,307.5	8,092.5	-1,215.0
Бусад биет бус хөрөнгө	778,302.0	699,458.0	-78,844.0
Дүн	8,044,504.1	4,628,380.5	-3,416,123.6

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн жилийн эцсийн 4,628,380.5 мянган төгрөгийн үлдэгдлийн 99,8 хувь буюу 4,619,657.1 мянган төгрөгийг сумын ЗДТГ, 0,03 хувь буюу 1,373.9 мянган төгрөгийг ИТХ, 0.02 хувь буюу 750.0 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сан, 0,15 хувь буюу 6,599.6 мянган төгрөгийг эмийн эргэлтийн сангийн хөрөнгө эзэлж байна. Дуусаагүй барилга, байгууламж дансны үлдэгдэл 290,121.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант хугацааны эцэст буюу сумын ЗДТГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/20 дугаар тушаалаар сумын төв доторх 2 км авто замын ажлын зардлыг 455,968.2 мянган төгрөгөөр хөрөнгө оруулалтын зардлаас зарцуулахаар шийдвэрлэж, тухайн ажилд олгосон 297,539.3 мянган төгрөгийн урьдчилгаа санхүүжилтийг тус дансанд бүртгэж тайлагнасантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Засаг даргын нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайланд:

- Улсын төсвийн байгууллагууд харьяа дээд байгууллагадаа нэгтгэгдэхтэй холбоотойгоор 2,719,446.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлж, үнэ төлбөргүй гарсан зардалд тайлагнаагүй байсныг аудитын явцад залруулж тайлагнасан.
- ИТХ-ын үнэ төлбөргүй бүртгэсэн 1,373.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг зөрүүтэй тайлагнасныг залруулсан.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 12,190.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 13,548.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	174.6		-174.6
Байгууллагад төлөх өглөг	25,564.0	12,190.0	-13,374.0
Дүн	25,738.6	12,190.0	-13,548.6

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 13,548.6 мянган төгрөгөөр буурсан нь улсын төсвийн байгууллагууд харьяа дээд байгууллагадаа нэгтгэх тул эрүүл мэндийн төвийн 17,549.0 мянган төгрөгийн өглөгийг шилжүүлсэнтэй холбоотой байна.

Өр төлбөрийн эцсийн үлдэгдэл 12,190.0 мянган төгрөг нь Мал хамгаалах санд тайлагнагдсан байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангийн өглөг байна.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 4,063,131.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,935,802.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,332,329.3	1,268,467.9	-1,063,861.4
Хуримтлагдсан үр дүн	2,746,982.7	1,833,071.9	-913,910.8
Өмнөх үеийн үр дүн	1,557,809.0	4,723,187.9	3,165,378.9
Тайлант үеийн үр дүн	1,189,173.7	-2,890,116.0	-4,079,289.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,919,621.3	961,591.5	-958,029.8
Дүн	6,998,933.3	4,063,131.3	-2,935,802.0

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 2,935,802.0 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн байгууллагуудын хөрөнгийг шилжүүлснээр засгийн газрын сан 1,063,861.4 мянган төгрөгөөр, хөрөнгийн дахин үнэлгээ 958,029.8 мянган төгрөгөөр буурч, өмнөх үеийн үр дүн 3,165,378.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант үеийн үр дүн 4,079,289.7 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн Баян сумын орон нутгийн төсвийн байгууллагуудын 2022 оны төсвийн төсөлд хүргүүлсэн саналыг шилэн дансанд нэгтгэн байршуулаагүй ба орлого, зардлыг тооцоолол, төлөвлөгөөг ирүүлээгүй.

Баян сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 16-ний өдрийн “сумын 2022 оны төсөв батлах тухай” 03 дугаар тогтоолоор 2022 онд төсөвт төвлөрүүлэх татварын ба татварын бус орлогыг 1,613,714.1 мянган төгрөгөөр, төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 846,438.6 мянган төгрөгөөр, орон нутгийн хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зардалд 821,827.1 мянган төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд 853,565.0 мянган төгрөгийг тус тус баталсан байна. Сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 230,182.7 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Баян сумын ИТХ-ын 2022 оны 7 дугаар сарын 01-ны өдрийн “Сумын 2022 оны төсөвт тодотгол хийх тухай” 04 дүгээр тогтоолоор 2022 оны төсвийн жилд зарцуулах зарлагын хэмжээг ЕБС-ийн нийтлэг үйлчилгээний зардлыг 39,058.3 мянган төгрөгөөр, Цэцэрлэгийн нийтлэг үйлчилгээний зардлыг 20,732.7 мянган төгрөгөөр, Соёлын төвийн нийтлэг үйлчилгээний зардлыг 14,363.5 мянган төгрөгөөр хасаж тодотгон баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвийн орлогоос 1,613,714.1 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 526,376.1 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдлээс 327,188.9 мянган төгрөг, төсвийн урьд оны шилжих үлдэгдлээс 821,827.1 мянган төгрөг, нийт 3,289,106.2 мянган төгрөгөөр бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,574,349.4 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгээр 526,376.1 мянган төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 81,661.6 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, 241,278.8 мянган төгрөгийн үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлж төсвийн тохируулга хийгдсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,079,503.3 мянган төгрөг буюу 64,9 хувьтай байгаа нь цалин хөлс, НДШ-ийн зардал 41,989.5 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой зардал 6,126.4 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 53.0 мянган төгрөг, эд хогшил,

урсгал засварын зардал 20.3 мянган төгрөг, дотоод томилолтын зардал 62.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 4,260.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 1,277.9 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 5.0 мянган төгрөг, хөрөнгийн зардал 876,090.0 мянган төгрөгөөр хэмнэснээс шалтгаалсан байна.

Цалин шимтгэлийн зардал орон тоо дутуу ажилласнаас, хөрөнгийн зардал тендер сонгон шалгаруулалттай холбоотойгоор хэмнэгдсэн байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага-үндсэн үйл	58,923.5	54,788.2	4,135.30	2.6
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- үндсэн үйл	1,207,260.3	976,748.2	230,512.10	47.0
3	Ерөнхий боловсролын сургууль-тогтмол зардал	191,603.2	190,103.5	1,499.70	9.1
4	Сургуулийн өмнөх боловсрол-тогтмол зардал	33,673.4	31,530.6	2,142.80	1.5
5	Соёлын үйлчилгээ-тогтмол зардал	54,030.3	53,943.3	87.00	2.6
6	Эрүүл мэндийн төв-тогтмол зардал	25,640.7	19,392.7	6,248.00	0.9
7	Хоршоо хөгжүүлэх сан- үндсэн үйл ажиллагааны зардал	239,775.4	55,972.4	183,803.00	2.7
8	Орон нутгийн хөгжлийн сан-хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ	1,390,657.8	697,024.4	693,633.40	33.5
	Дүн	3,201,564.6	2,079,503.3	1,122,061.3	100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар сумын Засаг даргын тамгын газар нь 60,870.3 мянган төгрөгийг төвлөрүүлэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 9 хөтөлбөрийн 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 11. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70105- Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	2022.01.01-2022.12.31	Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, тэргүүлэгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангах, Жилд 4-өөс доошгүй удаа хурал хийнэ.	Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, тэргүүлэгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангах, жилд 12 удаа хуралдсан байна. Хэрэгжилт 93,0%	58,923.5	54,788.2
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2022.01.01-2022.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хэрэгжүүлэх	Хэрэгжилт 80,9 хувь	1,207,260.3	976,748.2
3	70106-Хоршоо хөгжүүлэх сан	2022.01.01-2022.12.31	Хоршоо хөгжүүлэх сангийн дүрэм журмыг хэрэгжүүлэх	Хэрэгжилт 23,3%	239,775.40	55,972.40
4	71802-Ерөнхий боловсролын сургууль	2022.01.01-2022.12.31	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	99.2	191,603.2	190,103.5
5	71801-Сургуулийн өмнөх боловсрол	2022.01.01-2022.12.31	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	93.6	33,673.4	31,530.6
6	71702-Соёлын үйлчилгээ	2022.01.01-2022.12.31	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	99.8	54,030.3	53,943.3
7	71602-Эрүүл мэндийн төв	2022.01.01-2022.12.31	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	75.6	25,640.7	19,392.7
9	70106-Орон нутгийн хөгжлийн сан	2022.01.01-2022.12.31	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	50.1	1,390,657.8	697,024.4

Баян сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 16-ний өдрийн “сумын 2022 оны төсөв батлах тухай” 03 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга, байгууламж төсөл арга хэмжээний жагсаалтад Үерийн далангийн ажлыг 2022-203 онд гүйцэтгэх, 2022 онд 457,546.2 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр баталсан. Сумын ИТХ-ын 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 06 дугаар тогтоолоор үерийн далангийн төсөл арга хэмжээг өөрчилж, сум доторх 2 км авто замын ажил гэж өөрчилсөн байна.

Баян сумын ЗДТГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/20 дугаар тушаалаар сумын төв доторх 2 км авто замын ажлын зардлын 455,968.2 мянган төгрөгийг хөрөнгө оруулалтын зардлаас зарцуулахаар шийдвэрлэсэн байна. Тус ажлыг гүйцэтгэгч Неон гэгээ ХХК-д Сумын төв доторх авто замын ажлын 65,3%-н санхүүжилт болох 297,539.3 мянган төгрөгийг 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдөр шилжүүлж, дуусаагүй барилга, байгууламж зардлын дансанд бүртгэсэн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4-д “төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх”, 13.1.5-д “хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хуулиар батлагдсанаас хойш түүний төсөвт өртөг нэмэгдүүлэх үр дагавар бүхий нэмэлт шаардлагыг зохиогч, ашиглагч, захиалагчийн хяналт тавих этгээд гаргахгүй байх” гэж заасантай нийцэхгүй тул гүйцэтгэлийн аудитад шилжүүлэхээр шийдвэрлэсэн болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Баян сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын орлого бүрдүүлэлт, шилэн дансны мэдээллийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Майцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баян сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт сумын Засаг даргын 2023 оны 3 дугаар сарын 06-ний өдрийн 01/61 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2022 оны төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2022 оны төсвийг, суурь үзүүлэлтийг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн 2022 оны урсгал үйл ажиллагааны зардал 2,212,484.9 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 33,187.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 24,890.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Баян сумын Засаг дарга нь Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл ирүүлээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Баян сумын Засаг даргын шилэн дансанд албан үүрэг өөрчлөгдсөн Нямсүрэн ерөнхий нягтлан бодогчийн нэрийг солиогүй, тайлант онд байршуулах

мэдээллээс 16 мэдээллийг хугацаа хоцроож, худалдан авах ажиллагааны тайлангийн мэдээллийг байршуулаагүй төлөвтэй байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий Эмийн эргэлтийн сангийн 5,900.0 мянган төгрөгийн 1 орлогын гүйлгээ, 19,922.6 мянган төгрөгийн 3 зарлагын гүйлгээ мэдээлээгүй, Хоршоо хөгжүүлэх сангийн 61,080.1 мянган төгрөгийн орлогын 1, зарлагын 1 гүйлгээг мэдээлээгүй, Орон нутгийн хөгжлийн сангийн ЕБС-н спорт заалны 703,196.3 мянган төгрөгийн ажлын тендер шалгаруулалтын үр дүнгийн талаар мэдээллийг оруулаагүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баян сумын Засаг даргын эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн, сумын Засаг даргын 2022 оны 6 дугаар сарын 22-ний өдрийн 01/105 дугаартай албан бичгээр хэрэгжилтийг ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	2	24,115.1	2	24,115.1	
Зөвлөмж	16	400,748.7	16	400,748.7	100
Нийт дүн	18	424,863.8	18	424,863.8	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баян сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 3,681,956.8 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 3,681,956.8 мянган төгрөгийн алдааг залруулав.

1. Нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайланд улсын төсвийн байгууллагуудын 2,719,446.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 138,190.4 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлж үнэ төлбөргүй гарсан зардал дансанд бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон

төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

2. Нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайланд ОНХС-ийн 1,118.7 мянган төгрөгийн авлагыг бүртгэхдээ бусад орлогоор буруу тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “ангилал”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

3. Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд орон нутгийн төсөвт байгууллагуудад олгосон санхүүжилтийг 821,827.0 мянган төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “ангилал”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

4. ИТХ-ын санхүүгийн тайланд үнэ төлбөргүй бүртгэсэн 1,373.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “ангилал”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 1,263,443.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,263,443.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлого бүрдүүлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын батлагдсан төлөвлөгөө 1,613,714.1 мянган төгрөг, гүйцэтгэлээр 1,155,459.6 мянган төгрөг төвлөрч, батлагдсан төлөвлөгөө 71,6 хувиар биелж 458,254.5 мянган төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр жигд биелүүлэх

2. Орлого бүрдүүлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Орлогын гүйцэтгэлийн тодруулга тайланд төсвийн орлогын төлөвлөгөөг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар тодотгон батлагдсан дүнгээс 10,671.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийг аймгийн Татварын хэлтсийн аудитад ирүүлсэн 2022 оны төсвийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлээс 4,418.5 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан төлөвлөгөөнд өөрчлөлт орсон тохиолдолд аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст мэдэгдэн өөрчлөлтийг оруулж байх ба татварын байцаагчтай орлогын дүнг сар улирлаар тохирч байх

3. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансанд албан үүрэг өөрчлөгдсөн ерөнхий нягтлан бодогчийн нэрийг солиогүй, тайлант онд байршуулах мэдээллээс 16 мэдээллийг хугацаа хоцроож, худалдан авах ажиллагааны тайлангийн мэдээллийг байршуулаагүй төлөвтэй байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий Эмийн эргэлтийн сангийн 5,900.0 мянган төгрөгийн 1 орлогын гүйлгээ, 19,922.6 мянган төгрөгийн 3 зарлагын гүйлгээ мэдээлээгүй, Хоршоо хөгжүүлэх сангийн 61,080.1 мянган төгрөгийн орлогын 1, зарлагын 1 гүйлгээг мэдээлээгүй, Орон нутгийн хөгжлийн сангийн ЕБС-н спорт заалны 703,196.3 мянган төгрөгийн ажлын тендер шалгаруулалтын үр дүнгийн талаар мэдээллийг оруулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" гэж заасантай бүрэн нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн мэдээлэх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	4	3,681,956.8			4	3,681,956.8	4	3,681,956.8				
ЗДТГ	2	243,927.6			2	243,927.6	2	243,927.6				
ИТХ	1	154,000.0			1	154,000.0	1	154,000.0				
Дүн	7	4,079,884.4			7	4,079,884.4	7	4,079,884.4				

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаа лтны тоо	Тоо	Дүн
Засаг дарга	2	473,344.0					2	473,344.0				
ЗДТГ	2	8,092.9	1	286.9	1	7,806.0						
Дүн	4	481,436.9	1	286.9	1	7,806.0	2	473,344.0				

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Засаг дарга	1	0					1	0
ЗДТГ	1						1	
ОНХС	1	703,196.3					1	703,196.3
ХХС	1	61,080.1					1	61,080.1
ЭЭС	1	25,822.6					1	25,822.6
Дүн	5	790,099.0					5	790,099.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	5	790,099.0					5	790,099.0